



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ахмад настны үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/77/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: О.Наранбат Утас: 261628 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn Си Эс Ай Аудит ХХК-ийн захирал: Утас:99096584 Цахим хаяг: sevjidmaa@csiaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГА Л.ЭРДЭНЭХҮҮ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/2024
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ахмад настны үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Ажилчдыг шөнийн цагаар ажиллуулсны нэмэгдэл хөлсийг тооцож, олгохдоо хуульд заасан хувь хэмжээг 0.9 хувиар бууруулж ажилчдын эрх зүйн байдлыг дордуулан нийт 35 ажилтанд 25,455.9 мянган төгрөгийг дутуу олгосон,
- Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын 2021 оны А/188 дугаар тушаалаар баталсан төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, зардлын дундаж нормативийг 11,698.3 мянган төгрөгийг хэтрүүлэн хоол хүнсний зардлыг илүү зарцуулсан;
- Үйлчлүүлэгчийн тэтгэвэр, тэтгэмжээс авах 30 хувийн орлогод 26 хүний 6,223.5 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлж, авлагаар бүртгээгүй.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2-т "Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн" мөн 46.2.3-д "Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-д "Анхан шатны баримт бүрдүүлэх", 20 дугаар зүйлийн 20.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Нийгэм халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.18-д "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тогтоогдсон тэтгэврийнх нь 70 хувийг асруулж байгаа иргэнд, 30 хувийг тухайн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу олгоно." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Ахмад настны үндэсний төв байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээг угтаж, "Медиа боловсрол суваг" ХХК нь нийт 62,175.0 мянган төгрөгөөр "Ахмадын гэрт дөрвөн настууд" контент нэвтрүүлгийг бэлтгэж өгсөн байна.

Аудитын гол асуудал

Үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөхдөө асрамжийн байрны хүчин чадлаар буюу 250 үйлчлүүлэгчээр тооцож, 380,163.2 мянган төгрөгөөр төсөвлөсөн боловч тайлант оны дунджаар тэтгэвэр авагч ахмад настан 126 хүн, халамжийн тэтгэвэр авагч ахмад настан 55 хүн, нийт 181 үйлчлүүлэгчийн тэтгэвэр, тэтгэмжийн орлогын 30 хувь буюу 317,697.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 62,466.2 мянган төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>647,026,150.09</u>	<u>505,746,247.34</u>
33	АВЛАГА	43,829,460.83	28,628,081.70
335	Бусад авлага	43,829,460.83	28,628,081.70
3351	Байгууллагаас авах авлага	43,829,460.83	28,628,081.70
34	УРЬДЧИЛГАА	89,357,188.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	89,357,188.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	513,839,501.26	477,118,165.64
351	Түүхий эд материал	35,267,037.46	31,012,150.20
35130	Эм боох материал	35,267,037.46	31,012,150.20
354	Хангамжийн материал	391,872,463.80	365,166,015.44
35410	Бичиг хэргийн материал	1,247,600.00	685,900.00
35420	Аж ахуйн материал	223,348,179.89	125,011,782.00
35440	Түлш, шатах тослох материал	5,662,799.99	9,537,320.00
35460	Хүнсний материал	99,082,883.92	51,328,767.04
35470	Бусад хангамжийн материал	62,531,000.00	178,602,246.40
35600	Мал амьтад	86,700,000.00	80,940,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,238,833,705.92</u>	<u>10,048,089,709.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,238,833,705.92	10,048,089,709.07
392	Биет хөрөнгө	9,842,932,325.92	9,643,388,329.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,391,693,398.08	10,436,405,448.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,260,784,419.99)	(1,453,711,367.62)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	291,918,764.00	291,918,764.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(217,587,514.00)	(233,033,347.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,256,857,108.44	1,343,461,008.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(682,873,423.33)	(793,612,943.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	156,104,580.00	167,126,680.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(107,368,167.28)	(115,165,913.20)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	14,972,000.00	-
393	Биет бус хөрөнгө	395,901,380.00	404,701,380.00
39301	Программ хангамж	770,000.00	9,570,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	395,901,380.00	395,901,380.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10,885,859,856.01</u>	<u>10,553,835,956.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>980,902.49</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	980,902.49	-
413	Өглөг	980,902.49	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	980,902.49	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>10,884,878,953.52</u>	<u>10,553,835,956.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	10,884,878,953.52	10,553,835,956.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,264,908,232.00	1,264,908,232.00
51101	Өмч:- төрийн	1,264,908,232.00	1,264,908,232.00
512	Хуримтлагдсан үр дүн	8,815,044,882.48	8,484,001,885.37
51210	Өмнөх үеийн үр дүн	8,815,044,882.48	8,815,044,882.48
51220	Тайлант үеийн үр дүн	151,180,114.06	(331,042,997.11)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	804,925,839.04	804,925,839.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>10,885,859,856.01</u>	<u>10,553,835,956.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,238,507,896.40	4,053,271,701.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	349,385,596.40	481,676,401.20
120	Нийтлэг татварын бус орлого	349,385,596.40	481,676,401.20
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	348,515,596.40	481,046,401.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	235,815,388.40	317,697,041.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	112,700,208.00	163,349,360.00
120009	Бусад орлого	870,000.00	630,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,889,122,300.00	3,571,595,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,875,122,300.00	3,504,020,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,875,122,300.00	3,504,020,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,000,000.00	67,575,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	67,575,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,389,688,010.46	4,384,314,698.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,389,688,010.46	4,384,314,698.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,311,875,211.48	4,209,883,312.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,332,874,981.79	1,871,961,793.47
210101	Үндсэн цалин	896,578,293.81	1,101,963,868.40
210102	Нэмэгдэл	325,862,643.08	536,790,581.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,075,600.00	58,061,446.56
210104	Урамшуулал	50,358,444.90	175,145,897.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,015,571.47	236,353,298.19
210201	Тэтгэврийн даатгал	115,981,320.52	166,942,593.47
210202	Тэтгэмжийн даатгал	13,459,305.67	18,536,633.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,646,484.37	14,543,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,516,264.48	3,278,301.34
210205	Эрүүл мэндийн даатгал	25,412,196.43	33,051,969.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	228,809,894.01	343,160,645.82
210301	Гэрэл, цахилгаан	96,244,194.00	130,445,665.83
210302	Түлш, халаалт	121,895,700.01	196,921,879.99
210303	Цэвэр, бохир ус	10,670,000.00	15,793,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	113,692,672.70	146,650,487.30
210401	Бичиг хэрэг	2,430,220.00	2,663,350.00
210402	Тээвэр, шатахуун	33,741,400.00	20,443,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,522,914.00	2,074,002.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,892,000.00	4,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,896,138.70	101,905,135.29
210408	Бараа материал акталсны зардал	3,210,000.00	15,065,000.00

Ахмад настны үндэсний төвий 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	869,888,646.12	930,366,180.64
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	116,895,608.63	102,983,097.26
210502	Хоол, хүнс	563,291,532.09	709,405,095.18
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	189,701,505.40	117,977,988.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	116,552,931.00	195,663,842.00
210604	Урсгал засвар	116,552,931.00	195,663,842.00
2107	Томилолт, зочны зардал	3,976,000.00	-
210702	Дотоод албан томилолт	3,976,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,628,116.00	93,068,018.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,811,871.00	82,339,799.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	793,985.00	549,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	528,840.00	2,596,599.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	176,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,721,000.00	1,116,000.00
210807	Газрын төлбөр	96,420.00	2,966,620.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	382,436,398.39	392,659,046.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,110,000.00	42,260,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,136,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	344,190,398.39	350,399,046.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,812,798.98	174,431,386.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,759,800.00	92,078,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,459,800.00	89,778,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	2,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,052,998.98	82,352,886.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,052,998.98	82,352,886.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(151,180,114.06)</u>	<u>(331,042,997.11)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(151,180,114.06)</u>	<u>(331,042,997.11)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,126,859,717.58</u>	<u>3,933,137,741.20</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	237,737,417.58	361,542,441.20
120	Нийтлэг татварын бус орлого	237,737,417.58	361,542,441.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	236,867,417.58	317,697,041.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	235,815,388.40	317,697,041.20
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,052,029.18	-
120009	Бусад орлого	870,000.00	43,845,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,889,122,300.00	3,571,595,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,875,122,300.00	3,504,020,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,875,122,300.00	3,504,020,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,000,000.00	67,575,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	67,575,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,077,000,937.58</u>	<u>3,873,482,691.20</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,077,000,937.58	3,873,482,691.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,999,188,138.60	3,699,051,305.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,332,394,616.79	1,872,942,695.96
210101	Үндсэн цалин	897,081,809.04	1,101,947,069.36
210102	Нэмэгдэл	325,226,555.08	537,785,846.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,735,253.77	58,063,882.47
210104	Урамшуулал	50,350,998.90	175,145,897.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,129,094.81	235,739,237.36
210201	Тэтгэврийн даатгал	116,094,843.86	166,328,532.64
210202	Тэтгэмжийн даатгал	13,459,305.67	18,536,633.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,646,484.37	14,543,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,516,264.48	3,249,941.34
210205	Эрүүл мэндийн даатгал	25,412,196.43	33,080,329.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	239,280,994.00	346,719,965.83
210301	Гэрэл, цахилгаан	96,244,194.00	130,445,665.83
210302	Түлш, халаалт	127,558,500.00	200,796,400.00
210303	Цэвэр, бохир ус	15,478,300.00	15,477,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,982,534.00	61,227,164.01
210401	Бичиг хэрэг	1,726,820.00	1,048,900.00
210402	Тээвэр, шатахуун	22,353,100.00	12,482,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,522,914.00	2,075,402.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,344,300.00	5,087,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,035,400.00	40,533,262.00
2105	Нормативт зардал	839,560,846.00	883,864,100.00

Ахмад настны үндэсний төвий 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,592,196.00	66,334,200.00
210502	Хоол, хүнс	620,132,800.00	667,529,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	149,835,850.00	150,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,744,456.00	7,403,500.00
210604	Урсгал засвар	99,744,456.00	7,403,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,976,000.00	-
210702	Дотоод албан томилолт	3,976,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	245,983,597.00	291,154,642.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	236,716,352.00	280,426,423.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	793,985.00	549,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	488,840.00	2,502,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	216,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,172,000.00	1,116,000.00
210807	Газрын төлбөр	96,420.00	3,060,469.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,136,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,136,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,812,798.98	174,431,386.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,759,800.00	92,078,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,459,800.00	89,778,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	2,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,052,998.98	82,352,886.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,052,998.98	82,352,886.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>49,858,780.00</u>	<u>59,655,050.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,858,780.00	59,655,050.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,858,780.00	59,655,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,858,780.00	59,655,050.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,858,780.00	59,655,050.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(49,858,780.00)</u>	<u>(59,655,050.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,966,224,996.54	11,036,059,067.58
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,966,224,996.54	11,036,059,067.58
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(151,180,114.06)	(151,180,114.06)
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,815,044,882.48	10,884,878,953.52
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,815,044,882.48	10,884,878,953.52
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(331,042,997.11)	(331,042,997.11)
17	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,484,001,885.37	10,553,835,956.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,884,274,100.00	3,782,579,855.16	101,694,244.84	97.4
УРСГАЛ ЗАРДАЛ	3,884,274,100.00	3,782,579,855.16	101,694,244.84	97.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,792,105,000.00	3,690,501,355.16	101,603,644.84	97.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,905,235,400.00	1,872,942,695.96	32,292,704.04	98.3
Үндсэн цалин	1,127,006,300.00	1,101,947,069.36	25,059,230.64	97.8
Нэмэгдэл	620,328,500.00	537,785,846.67	82,542,653.33	86.7
Унаа хоолны хөнгөлөлт	92,202,000.00	58,063,882.47	34,138,117.53	63.0
Урамшуулал	65,698,600.00	175,145,897.46	(109,447,297.46)	266.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,904,700.00	235,739,237.36	6,165,462.64	97.5
Тэтгэврийн даатгал	169,107,300.00	166,328,532.64	2,778,767.36	98.4
Тэтгэмжийн даатгал	18,199,300.00	18,536,633.97	(337,333.97)	101.9
ҮОМШӨ-ний даатгал	14,559,500.00	14,543,800.00	15,700.00	99.9
Ажилгүйдлийн даатгал	3,639,800.00	3,249,941.34	389,858.66	89.3
Эрүүл мэндийн даатгал	36,398,800.00	33,080,329.41	3,318,470.59	90.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	346,805,100.00	346,719,965.83	85,134.17	100.0
Гэрэл, цахилгаан	130,511,700.00	130,445,665.83	66,034.17	99.9
Түлш, халаалт	200,815,100.00	200,796,400.00	18,700.00	100.0
Цэвэр, бохир ус	15,478,300.00	15,477,900.00	400.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	57,119,700.00	57,097,164.01	22,535.99	100.0
Бичиг хэрэг	428,400.00	418,900.00	9,500.00	97.8
Тээвэр, шатахуун	12,482,500.00	12,482,200.00	300.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,080,700.00	2,075,402.01	5,297.99	99.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,092,700.00	5,087,400.00	5,300.00	99.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,035,400.00	37,033,262.00	2,138.00	100.0
Нормативт зардал	837,159,500.00	837,064,100.00	95,400.00	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,597,900.00	69,534,200.00	63,700.00	99.9
Хоол, хүнс	617,534,000.00	617,529,900.00	4,100.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,027,600.00	150,000,000.00	27,600.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	12,587,400.00	12,580,600.00	6,800.00	99.9
Урсгал засвар	12,587,400.00	12,580,600.00	6,800.00	99.9
Томилолт, зочны зардал	84,500.00	-	84,500.00	-
Дотоод албан томилолт	84,500.00	-	84,500.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	391,208,700.00	328,357,592.00	62,851,108.00	83.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	380,163,200.00	317,629,373.00	62,533,827.00	83.6

Ахмад настны үндэсний төвий 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,511,100.00	3,500,000.00	11,100.00	99.7
Даатгалын үйлчилгээ	549,000.00	549,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,589,200.00	2,502,750.00	86,450.00	96.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,120,600.00	1,116,000.00	4,600.00	99.6
Газрын төлбөр	3,275,600.00	3,060,469.00	215,131.00	93.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,169,100.00	92,078,500.00	90,600.00	99.9
Бусад урсгал шилжүүлэг	92,169,100.00	92,078,500.00	90,600.00	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	89,778,500.00	89,778,500.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,390,600.00	2,300,000.00	90,600.00	96.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,884,274,100.00	3,782,579,855.16	101,694,244.84	98.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,504,110,900.00	3,464,882,813.96	39,228,086.04	100.0
Улсын төсвөөс санхүүжих	3,504,110,900.00	3,464,882,813.96	39,228,086.04	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	380,163,200.00	317,697,041.20	62,466,158.80	83.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	380,163,200.00	317,697,041.20	62,466,158.80	83.6
АЖИЛЛАГСДЫН ТОО	127	111	16	87.4
Удирдах ажилтан	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	42	31	11	73.8
Үйлчлэх ажилтан	80	74	6	92.5
Гэрээт ажилтан	4	4	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		67,575,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ		67,575,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		67,575,000.00
Хангамж, бараа материалын зардал		3,500,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,500,000.00
Нормативт зардал		50,000,000.00
Хоол, хүнс		50,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		14,075,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		14,075,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		67,575,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		67,575,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		67,575,000.00

Ахмад настны үндэсний төвий 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 162.3 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 162.3 сая төгрөгийн 3 алдааг залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ажилчдын илүү цагийг завсрын аудитын зөвлөмжийн дагуу дахин тооцоолол хийж 3 сарын дундаж цалингаас тооцон зөрүүг тооцон олгосон байна.	1	7,150.1					1	7,150.1				
Асрамжийн үйлчилгээний цахим уулзалтад зориулж авсан таблет 1,599.0 мянган төгрөг, нотебүүк 2,420.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бараа материалын дансны дансанд бүртгэсэн байна.	1	4,019.0					1	4,019.0				
Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг тулган баталгаажуулахад санхүүгийн байдал болон үр дүнгийн тайлангийн тайлант үеийн үр дүн 151,180.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	151,180.1					1	151,180.1				
Дүн	3	162,349.2					3	162,349.2				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Ахмад настны үндэсний төвий 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитаар нийт 53.2 сая төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 9.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 17.9 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 25.4 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ахмад настны үндэсний төв нь тайлант онд тэтгэвэр тогтоолгосон Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2-т "Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, 46.2.3-т "Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн" нэр бүхий 8 албан хаагчийг үндсэн ажилтнаар ажиллуулж 9,869.1 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна.	1	9,869,1	1	9,869,1								
Ахмад настны үндэсний төв нь тайлант онд Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж буй үйлчлүүлэгчийн нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэврээс бүрдүүлэх 30 хувийн орлогод 26 хүний 6,223.5 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлж, авлагаар бүртгээгүй байна.	1	6,223.5			1	6,223.5						
Ахмад настны үндэсний төв нь төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны	1	11,698.3			1	11,698.3						

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Ахмад настны үндэсний төвий 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

норм, зардлын дундаж нормативыг хэтрүүлж, нийт 11,698.3 мянган төгрөгийг хоол хүнсний зардлыг илүү зарцуулсан байна.												
Гал тогооны их засварын ажлыг гүйцэтгэхэд тендер зарлалгүй, нийт 68,655.6 мянган төгрөгийг 4 хувааж, шууд гэрээ байгуулсан байна.	1						1	-				
Ажилчдад шөнийн цагаар ажиллуулсны нэмэгдэл хөлсийг тооцож, олгохдоо хуульд заасан хувь хэмжээг 0.9 хувиар бууруулж ажилчдын эрх зүйн байдлыг дордуулан нийт 35 ажилтанд 25,455.9 мянган төгрөгийг дутуу олгосон	1	25,455.9					1	25,455.9				
Дүн	5	53,246.9	1	9,869,1	2	17,921.9	2	25,455.9				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тус байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 160 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 мөнгөн гүйлгээний 91,533.2 мянган төгрөг, зарлагын 1 мөнгөн	1	-	1	-		

Ахмад настны үндэсний төвий 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

гүйлгээний 39,558.1 мянган төгрөг нийт 4 мөнгөн гүйлгээний 131,091.3 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.						
Дүн	1		1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн	1		1			